

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗАР НУТГИЙН НЭРИЙН ХУВЬСАЛ

Ц.Баттулга

0. Оршил

1. Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн уламжлал
2. Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн өөрчлөлт, хувьсал
3. Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн өөрчлөлтийн зарим сөрөг үр дагавар

0. Оршил

Баян-Өлгий аймгийн газар усны нэрийн өөрчлөлтийн талаар өгүүлэхийн тулд, 93 мянган хүн амтай тус аймгийн хүн амын 93 хувийг эзлэх¹ казах үндэстний түүхийн товчийг дурдах нь зүйтэй болов уу.

Анх 1890-ээд оноос Шыбыр-Айгыр, Каракас, Молхи хэмээх гурван овгийнхон Монгол нутагт нүүж ирсэн бөгөөд 1895 онд Ховдын амбанд есөн цагааны бэлэг барьж түр суух зөвшөөрөл авч байсан аж. Монгол улсад дагаар орох хүсэлтээ Богд гэгээний засгийн газарт ирүүлснийг 1917 оны 3-р сарын 23-нд ёсоор болгож улмаар хошуу, сумын зохион байгуулалтад оруулж толгойлогч нарт нь хэргэм, тамга олгож Шерүүч, Шыбыр-Айгыр, Ботохара хэмээх гурван хошуу болгожээ.

Хожим Ардын засгийн газраас 1925 онд, дайн самууны хөлөөс дүрвэж Орос, Шинжаанаас ирсэн хасагуудыг нэгтгэн Шерүүч, Хошах, Ботохара, Шыбыр-Айгыр, Байхадам гэсэн таван хошуу байгуулжээ². 1940 оны 8-р сард Баян-Өлгий аймаг байгуулж баруун хязгаарт нутаглаж байсан хасагуудыг харьяалуулсан бөгөөд эдүгээ ч тус аймагт төвлөрөн суусаар байна.

Энэхүү үйл явдал нь нутгийн уугуул иргэд шилжих, улмаар Баян-Өлгий аймгийн газар нутгийн язгуурын монгол нэр хувьсан өөрчлөгдөх үндсэн шалтгаан болсон бололтой.

1. Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн уламжлал

Өдгөөх Баян-Өлгий аймгийн газар нутгийн дийлэнх хэсгийг Алтайн Урианхайн долоон хошууны газар нутаг бүрдүүлж өгсөн түүхтэй. Тиймээс ч Баян-Өлгий аймгийн газар нутаг монгол нэртэй байсан бөгөөд XIX зууны сүүл, XX зууны эхэн үеийн газрын зургууд үүнийг баттай гэрчилнэ. Мэдээж, ойрад аман аялгууны нэгэн салбар болох Алтайн Урианхайн салбар аман аялгуугаар тэмдэглэгдсэн, нэрлэгдсэн газар нутаг, мөн тува хэлээр нэрлэсэн нэрс бас ч байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Одоогийн Цэнгэл сумын зарим газрын нэр тува хэлээр тэмдэглэгдсэн байх жишээтэй.

¹ info@bayan-olgi.gov.mn

² Нямбуу Х, Монголын угсаатны зүйн удиртгал, Улаанбаатар, 1992, 130-131-р тал.

Ц.Баттулга

Монгол улсын их сургууль
ch_tusgalt@yahoo.com

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

2. Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн өөрчлөлт, хувьсал

Баян-Өлгий аймгийн цахим танилцуулга-д “БАЯН-ӨЛГИЙ буюу БАЙ-БЕСИК АЙМАГЫ” хэмээн буй. Энэ ч газрын нэрийн өөрчлөгдөх, өөрөөр нэрлэх шалтгааны бас нэгэн сэжиг хэмээн үзэж болно.

Өөрөөр хэлбэл, Монгол улсын Засгийн газрын шийдвэр, тогтоолоор баталгаажсан, аймгийн “Баян-Өлгий” гэх нэрийг орчуулан хэрэглэж байгаа тохиолдолд газар нутгийн нэрийг орчуулж нэрлэх нь энгийн, бас байх л зүйлийн нэг болно.

Үүнээс үүдээд, Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн өөрчлөлт нь монгол нэрийг хасаг хэлнээ орчуулж хэрэглэсэнтэй шууд холбоотой юу гэсэн асуулт гарна.

Хэдийгээр, газар усны монгол нэрийг шууд орчуулж хэрэглэсэн нь үндсэн нэг шалтгаан яах аргагүй мөн боловч судлан үзвэл, Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн өөрчлөлт, хувьсал нь дотоод, гадаад хүчин зүйлсээс улбаатай хэд хэдэн шалтгаанаас үүдэлтэй ажээ. Үүнд,

Нэгдүгээрт, Монгол газар усны нэрийг хасаг хэлнээ орчуулж хэрэглэснээс үүдэлтэй хувьсал

Хоёрдугаарт, Уугуул иргэдийн шилжилт хөдөлгөөнөөс улбаатай буюу тухайн газар усны монгол нэрийг мэдэхгүйгээс дур дураараа нэрлэснээс үүдэлтэй хувьсал

Гуравдугаарт, тухайн газар усны монгол нэр байсаар байтал, зориудаар өөрчлөн нэрлэснээс үүдэлтэй хувьсал

Дөрөвдүгээрт, Монгол нэрийг сунжруулан дуудсанаас үүдэлтэй хувьсал гэсэн үндсэн дөрвөн шалтгааныг дурдаж болно.

Монгол газар усны нэрийг хасаг хэлнээ орчуулж хэрэглэснээс үүдэлтэй хувьсал

Газар, усны нэрийг хасаг хэлнээ орчуулж хэрэглэснээс үүдсэн өөрчлөлт, хувьсал хамгийн түгээмэл ажиглагдаж байна. Жишээ нь

Таван Богд - бес богда,

Цоохор нуур - шыбар көл

Цагаан нуур - ақ көл гэх мэт.

Албан бус судалгаанаас үзэхэд, Баян-Өлгий аймгийн газар нутгийн 90 гаруй хувь уугуул монгол нэр нь ямар нэгэн хэлбэрээр хувьсаж өөрчлөгдсөн буюу хасаг нэртэй болсон гэх судалгаа байна.

Бид БСШУЯ-ны захиалгаар 2005-2007 онд хэрэгжүүлсэн “Монгол Алтайн баруун хэсгийн түүх, соёлын дурсгалууд-1” төслийн хүрээнд тус аймгийн бүх сумдын нутгаар хээрийн хайгуул, судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүн хэвлэгдэж олон нийтийн хүртээл болсон билээ³.

Уг судалгааны ажлын хүрээнд Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэр хэрхэн өөрчлөгдөж, хувьсаж байгааг бид нүдээр үзсэн бөгөөд дурсгалуудыг газрын зургийн уламжлалт нэрсийг үндэслэн тодорхойлсон юм. Газрын зурагт тэмдэглэгдээгүй зарим нэрийг тухайн газарт оршин сууж байсан иргэдийн нэрлэснээр тэмдэглэсэн билээ.

2010-2014 онд мөн Баян-Өлгий аймгийн нутагт ажилласан бөгөөд газар нутгийн монгол нэр эрчимтэй хувьсан өөрчлөгдөж байгаа нь илт ажиглагдаж байсан болно. Түүнчлэн өмнө нэрлэж байсан хасаг нэрс нь өөрчлөгдөх, хувьсах, тэс өөрөөр нэрлэсэн тохиолдол ч цөөнгүй байв.

Тухайлбал, 2010 онд Болат гэдэг айл өвөлжсөн бол Болатын өвөлжөө, 2012 онд Ханат гэдэг айл өвөлжсөнөөс Ханатын өвөлжөө, 2013 онд Женисхан өвөлжих болсон учраас Женисханы өвөлжөө гэх жишээтэй. Эл өвөлжөөний монгол нэр нь Ихэрийн өвөлжөө, арын уулынх нь нэр Ихэр. Угтаа Ихэрийн уулын энгэрт орших Ихэрийн өвөлжөө мөн билээ. Гэтэл

³ Ц.Төрбат, Д.Баяр, Д.Цэвээндорж, Ц.Баттулга, Н.Баярхүү, Т.Идэрхангай, П.Х.Жискар, Монгол Алтайн археологийн дурсгалууд I, Улаанбаатар, 2009, 424 дугаар тал.

монгол нэр нь мартагдаж, Болатын өвөлжөөний арын уул, хоёр жилийн дараа Ханатын өвөлжөөний арын уул, нэг жилийн дараа Женисханы өвөлжөөний уул, эсвэл Женисханы уул болох жишээтэй.

Энэ мэтээс үүдээд, Баян-Өлгий аймгийн газрын нэр тун тогтворгүй, байнга өөрчлөгдөн хувьсах шинжтэй байгаа гэж хэлж болно.

Газрын нэрийн тогтворгүй байдал нь Монголын түүх, соёлын дурсгалын судлалд ч сөргөөр нөлөөлөх хандлагатай байна. Түүх, соёлын дурсгал бүхий газрын нэр өөрчлөгдөж байдаг тул газрын нэрийн өөрчлөлттэй холбоотойгоор нэг дурсгалыг хоёр өөр нэрээр нэрлэх, улмаар хоёр өөр дурсгал мэтээр ойлгох, судлахаар очигсод төөрч будилах, цаг өдөр алдах нь энүүхэнд болжээ.

Уугуул иргэдийн шилжилт хөдөлгөөнөөс улбаатай буюу тухайн газрын монгол нэрийг мэдэхгүйгээс үүдэлтэй хувьсал

Баян-Өлгий аймгийн Улаанхус, Баяннуур, Дэлүүн, Толбо зэрэг суманд нэг ч монгол айл байхгүй, Бугат, Цагааннуур, Ногооннуур, Сагсай сумын нутагт 20 хүрэхгүй монгол айл өрх байх ажээ. Нэгэн цагт хасаг айл огт байгаагүй байсан энэ нутаг өдгөө монгол айл байхгүй болсон нь нутгийн уугуул монгол иргэдийн шилжилт, хөдөлгөөнтэй холбоотой.

Уугуул иргэд байхгүй, нутгийн газар усны нэр мэдэх монгол хүн байхгүйгээс уулын төрх байдалд тааруулж өөрсдийн дураар нэрлэх тохиолдол цөөнгүй. Өөр өөрсдийн дураар гэж байгаагийн учир, нэг нь толгой гэж байхад нөгөө даваа, бас нэгэн тэнд одоо нутаглаж байгаа айлын эзний нэрээр, жишээ нь Бауржаны даваа, Бауржаны хөтөл гэх мэт. Тиймээс газар нутгийн тогтсон нэр бараг байхгүй болох хандлага ажиглагдаж байна.

Гуравдугаарт, тухайн газар усны монгол нэр байсаар байтал, зориудаар өөрчлөн нэрлэснээс үүдэлтэй хувьсал

Алтай сумын Нүцгэний хавцал, Нүцгэний гол гэж буй бөгөөд түүнийг Кабсеметийн хавцал, Кабсамет сайы- Кабсаметийн сайр, Жаланаш өзөн- Жаланаш гол хэмээн өөрчилж өдгөө нэрлэж байх жишээтэй.

Сагсай сумын Гашуун нуурын буган хөшөөг Зарымханнаң күзеуи бұғы тасы - Зарымханы намаржааны буган чулуу, Гашуун нуурыг-Сасык көл буюу Өмхий нуур гэж нэрлэх болсон байна⁴.

Монголын түүх соёлын холбогдолт ном сурвалжид тэмдэглэгдсэн, нутгийн уугуул иргэд одоо ч тэр нэрээр нь нэрлэсээр байгаа газрын нэрийг, тийм нэртэй газар мэдэхгүй, байхгүй гэж мэлзэх, угаасаа ийм нэртэй байсан гэж шинэ өгсөн нэрээр бичүүлэх, итгүүлэхийг хичээх нь цөөнгүй, сум орон нутгийн удирдлага, аймгийн төрийн байгууллага ч газрын зураг дахь нэр, одоо ч уугуул монголчуудын нэрлэсээр байгаа монгол нэрийг үл тоомсорлох хандлага ажиглагдаж байна.

Газрын монгол нэрээр асуух, яагаад ийм нэртэй болсон, урьд монгол нэртэй байсан гэх зэргээр лавлахад илт уурлаж ундууцах, монгол хэл мэдэхгүй гэх зэргээр аль болох монгол нэр хэлэхийг “цээрлэх” нь бараг “хасаг хүмүүсийн ёс” болсон мэт санагдсаныг нуух юун. Монгол хэл мэдэхгүй Монгол улсын иргэд хэт олширсон нь тухайн газар усны монгол нэр байсаар байтал, зориудаар өөрчлөн нэрлэх үзэгдэл даамжирах нэг нөхцлийг бүрдүүлж байна.

Дөрөвдүгээрт, Монгол нэрийг сунжруулан дуудсанаас үүдэлтэй хувьсал

Ёлт буюу ёл шувуут гэх утгатай газрыг өдгөө сунжруулан Жолты гэж дуудах, рашаан усны хажуугаар чихэр өвс их ургадаг тул Чихэртэй гэж нэрлэсэн, эрт цагаас Чихэртэйн

⁴ Б.Өмирбек, Г.Золбаяр, А.Ансаган, Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр дахь түүх соёлын дурсгалууд, Улаанбаатар, 2009, 21 дүгээр тал.

рашаан гэж алдартай бөгөөд өдгөө Шегиртай болж сунжирсан, Ямаат гэх газрын нэр Жаматы болж сунжирсан байх жишээтэй.

Уг нь хасаг хэлээр ямааг ешкі, янгир ямааг тау теке, тау ешкі хэмээн нэрлэдэг. Гэтэл ямаат нь жаматы болж хувирсан нь хожим нэгэн цагт уг газрын нэрийг таних, утгыг тодруулахад бэрхтэй болох нь лавтай. Шивээт Хайрхан уулыг Жебеті қайырынқын, Ирмэгт гэх газрыг Өрмегейт гэх мэтээр сунжирч монгол нэрийг мэдэхүйеэ бэрх болсон олон жишээ дурдаж болно.

3. Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн өөрчлөлтийн зарим сөрөг үр дагавар

- Монгол газрын зургийн нэрээр Баян-Өлгий аймагт судалгаа хийхэд нэн бэрхтэй болсон. Учир нь монгол байхгүй, дан хасаг нэртэй болсон бөгөөд хөдөө орон нутагт амьдарч байгаа иргэдийн дийлэнх нь монгол хэл мэдэхгүйгээс өмнө нь судалгааны эргэлтэд уг газрын нэрээр нэрлэсэн дурсгалыг олж судлахад бэрхтэй байна.

- Өвөлжөө, хаваржааг тухайн газар одоо нутаглаж байгаа айлын гэрийн эзний нэрээр нэрлэх тохиолдол их байна. Энэ нь тухайн үед газрын нэр мэт боловч хэдэн жилийн дараа эргээд очиход дахиад өөрчлөгдсөн байх жишээтэй. Жишээ нь: Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Бага Ойгор уулын эхний өвөлжөөг Зүүн оройн өвөлжөө хэмээгээд уг өвөлжөөний хаднаа зураг, эртний бичгийн дурсгал байгааг 1990 онд хээрийн судалгааны тайланд өгүүлсэн байдаг. 2003 онд уг газар очиход Темиржаны өвөлжөө гэдэг нэртэй газар. Зүүн оройн өвөлжөө гэж байхгүй, Темиржаны өвөлжөөний хадны зураг бичиг гэж нэрлэдэг гэж байсан билээ.

Энэ зун буюу 2014 оны 8-р сарын 6-нд уг газар дахин судалгаа хийхээр очиж өвөлжөөнд ирээд байсан хүнээс “Темиржаны өвөлжөө” гэдэг газар мөн биз дээ гэхэд тийм хүн мэдэхгүй, одоо манай хүүгийнх өвөлжиж байгаа. Болатын өвөлжөө гэдэг газар. Бага Ойгор уул мөн биз дээ, энэ хавьд байгаа хадны Бага Ойгорын хадны зураг гэж номд бичсэн байна гэхэд тийм газар биш. Бага Ойгор гэдэг газар байхгүй.

Номонд худал бичсэн байна, анх ирсэн хүн газрын нэрийг мэдэхгүйгээс тэгэж бичсэн байх. Уучлаарай, газрын зурагт тийнхүү тэмдэглэсэн байна гэхэд, газрын зурагт худал тэмдэглэсэн байх, Энэ газрыг “Уусай” гэдэг. “Уусай” гэдэг нэрийн учрыг лавлахад, “Уусай” нэгэн хортой өвс ургадаг. Энэ газрын мал мэддэг болохоор иддэггүй. Харин өөр газраас ирсэн мал идээд шууд хордож үхдэг. Тийм болохоор тэр хортой өвсний нэрээр энэ газрыг нэрлэсэн байна” гэж тайлбарлаж байлаа. Энэ газар өвөлжөөний нэрийг хэлж өгнө үү гэхэд “Уусай тау Болат кистау - Уусай уулын Болатын өвөлжөө” гэж байлаа. Ийнхүү 11 жилийн дараа очиход газрын нэр хэрхэн өөрчлөгдөж байгаа нь тодорхой байсан билээ.

Мөн түүнчлэн газрын зурагт хүртэл газрын нэрийг худал тэмдэглэсэн, түүх соёлын дурсгалт газрын нэрийг ч худал бичиж үлдээжээ гэж мэдэхгүй хүн дүгнэхэд хүргэж байв.

Хөдөө орон нутагт, монгол хэл мэдэх хүн “бараг байхгүй” болж, газар усны нэр байтугай монголоор зам асуухад хариулах, заах хүн олоход бэрх болжээ.

Монгол хэл мэдэхгүй, Монгол улсын иргэд олон байгаа нь газрын нэрийн өөрчлөлт, хувьсалын үндсэн гол шалтгааны нэг бололтой. Гэхдээ “хариутай бол бариутай” гэгчээр “хасаг хэлтэй” бол “монгол хэл”-тэй болох тохиолдол цөөнгүй ажээ.

Газрын нэр хэрхэн өөрчлөгдөж байгааг баттай нотлох тодорхой баримт бол түүх соёлын дурсгалт газрын нэр болно.

Нэгэн номоос жишээ дурдвал:

- Цагаан Асгатын буган хөшөө-Ақ қорым бұғы тасы
- Қызыл жаматы тауы-Улаан ямаат уул
- Қара жаматы тауы-Хар ямаат уул
- Шивээт Хайрхан, Цагаан айрагийн голын хадын зураг-Жебеті қайырынқын Ақ айрықдағы тасдағы сұлба суреттер
- Хойд Хөлцөөтийн хадны зураг-Тасты көлшейт тас сұлба суреттері

- Баг Харгайт амны хүн чулуу- Кіші қарағай аузындағы кісі тас-Бага Харгайтын амны хүн чулуу. (Угтаа баг буюу багц харгайт гэх газрын нэрийн утгыг буруу ухаж ойлгосноос “бага буюу жижиг Харгайт болжээ)
- Ёлтын хүн чулуу-Жолты, Қорабай кісі тас-Жолты, Корабайн хүн чулуу
- Цөгцийн арал-кұлыбай арал кісі тас-Күлбайн арлын хүн чулуу
- Алтай сум Нүцгэний голын зуслангийн хүн чулуу-Жалаңаштын өзені, жайлаудағы кісі тас-Жаланашын гол, зуслан дахь хүн чулуу
- Цагаан булгийн хүн чулуу-Ыдыгуйхын кісі тас-Ыдыгуйхын хүн чулуу
- Чихэртэйн голын хүн чулуу-Шегіртайдың кісі тас-Шегиртай дахь хүн чулуу
- Алтай сумын Нүцгэний хавцалын Нүцгэний голын хадны оршуулга-Қабсамет сайы Жалаңаш өзені жартас бейіті-Хабсеметийн сайр, Жаланашын гол, Жартасын оршуулга
- Цэнгэл сум-Мечит сайгийн тахилын хашлага-Мешіт сау табыну ошағы⁵ гэх мэт.

“Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр дахь түүх соёлын дурсгалууд” хэмээх номын зохиогчдыг буруутгаж байгаа хэрэг огт биш, уул ус, газар нутгийн монгол нэрийн орчуулга хэмээн зөвтгөө гэтэл монгол нэр нь багагүй өөрчлөгджээ.

Өөрөөр хэлбэл, үнэндээ орон нутагт, амьдрал дээр газрын нэр, ялангуяа түүх, соёлын дурсгалт газрын нэр хэрхэн өөрчлөгдөж буйг харуулсан баттай баримт, нотолгоо энэ болохоос бус, зохиогчид өчүүхэн ч буруугүй юм.

Сүүлийн жилүүдэд, ялангуяа Баян-Өлгий аймгийн нутгаас илэрсэн түүх, соёлын дурсгалын нэр зөрүүтэй болох чиг хандлага ажиглагдаж, энэ нь улмаар нэг дурсгалыг хоёр өөр дурсгал мэтээр ойлгох, судлаачдын дунд маргаан үүсгэх гол шалтгаан болж байна. Жишээ болгож, бидэнд тохиолдож байгаа зарим бэрхшээлээс дурдвал, эртний үсэг бичиг судлаачдын хувьд, газрын нэрийн өөрчлөлтөөс үүдэлтэй олон улсын чанартай маргаан, үл ойлголцол гарахад хүрч байгааг тэмдэглэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, Баян-Өлгий аймгийн нутаг дахь руни бичгийн зарим дурсгалын байгаа газрын нэрийг, уг дурсгалын нэрийг өөрчлөх, эсвээс хасаг хэлнээ орчуулж мэдээллэх нь түгээмэл байна.

Нэрийн өөрчлөлт, орчуулга зэргийг гадаад, дотоодын зарим эрдэмтэд тэр бүр мэдэхгүй тул хуучин дурсгалын шинэ нэр үүсэх, өмнө нь судлагдаагүй “шинэ дурсгал илрүүлэх” нь цөөнгүй. Хэдийгээр нэр өөрчлөгдөх нь уг дурсгалын судлалд төдий л нөлөөлөхгүй боловч эрдэмтдийг төөрөгдүүлж, цаг зав дэмий гарздах нөхцөл бүрдүүлж, маргаан үүсэх шалтгаан болж буйгаараа ихээхэн хор хохиролтой болно.

Энэ нь Баян-Өлгий аймгийн газар нутгийн нэрийн өөрчлөлтийн хор уршиг, зарим сөрөг үр дагаврын зөвхөн нэг жишээ юм.

Эцэст тэмдэглэхэд, газрын нэр түүхэн чухал сурвалж төдийгүй тусгаар тогтнолын баталгаа билээ. Тиймээс олон зуун жил дамжин уламжлагдаж ирсэн газрын нэрийг санаатай болон санамсаргүйгээр өөрчлөх, хувиргах бүдгэрүүлэх нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь дамжиггүй.

Нөгөө талаар, газар усны монгол нэртэй хамт уугуул монголчууд байсан түүх ч аажмаар бүдгэрч байгааг эрхбиш анхаарах нь зүйтэй санагдана.

НОМЗҮЙ

Ц.Гантулга, Алтайн Урианхайчууд, I дэвтэр, хоёр дахь хэвлэл, Улаанбаатар, 2014.

Х.Нямбуу, Монголын угсаатны зүйн удиртгал, Улаанбаатар, 1992.

Б.Өмирбек, Г.Золбаяр, А.Ансаган, Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын дурсгалууд, Улаанбаатар, 2009.

Э.Равдан, Ж.Нарангарав, Монгол газар нутгийн нэрийн хувьсалын толь, Улаанбаатар, 2011.

Ц.Төрбат, Д.Баяр, Д.Цэвээндорж, Ц.Баттулга, Н.Баярхүү, Т.Идэрхангай, П.Х.Жискара, Монгол Алтайн археологийн дурсгалууд I, Улаанбаатар, 2009.

⁵ Б.Өмирбек, Г.Золбаяр, А.Ансаган, Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр дахь түүх соёлын дурсгалууд, Улаанбаатар, 2009.

SUMMURY

The paper has three sections, which provide accounts of the tradition for place naming, the evolution of place names and some negative consequences of the evolution of place names in Bayan-Ulgii province.

The first part analyzes the past or traditions of place names in Bayan-Ulgii province and mentioned in the history of khasag people-a national minority, who have lived in the region for over a century.

The second part provides explanations about some reasons for the evolution of the place names in this area. Even in the e-introduction version of Bayan-Ulgii province, the word Bayan-Ulgii was translated into the khasag language as БАЙ-БЕСИКАЙМАҒЫ". In other words, even the name of the province that has been endorsed by the government decree was translated, therefore it is not surprising that other place names are being altered or translated. In addition, changes due to the literal translation, there are some other reasons for this evolution, too.

The place naming changes in the territory of Bayan-Ulgii province have internal and external causes. Firstly, Mongolian place names are being translated into the Khasag language. Secondly, the people who moved in have named the places differently in comparison with the previous use because of the migration of the native residents. Thirdly, residents have purposely changed some place names even if they knew Mongolian names. Fourthly, some Mongolian names have been pronounced incorrectly.

In the third section, we provide accounts for about some negative consequences of this evolution in Mongolian place names of Bayan-Ulgii province.

It has become extremely difficult to do research work in the territory of the province by using the names labeled in Mongolian geographic maps.

The places are being named with personal names of the local people who are living in the area and the new settlers rename places, too.

Recently, disputes have risen among the researchers as they differently named the same place. Furthermore, such a practice is misleading and wasting researchers' time and money. These are just the examples of consequences of the place name changes in Bayan-Ulgii province.

In conclusion, place names are not only historical sources, but also they present claims for boundaries of a country under its controls, so they serve as an aid for showing the territory of an independent country. On that account, changing or defusing the place names that have been used for a long time purposely or accidentally may cause problems for our national security. On the other hand, the history of original Mongolians is being defused with the change of Mongolian place names.